

## ТАНИЛЦУУЛГА

### Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй цагийн иргэдэд ижил, тэгш хүртээх зорилгоор үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэн зарцуулахад чиглэсэн. Энэ ч агуулгаар тус сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор стратегийн ач холбогдолтой гэж тодорхойлох ордын дийлэнхийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нь салбарын хувьд ихээхэн эрсдэл бүхий нөхцөл байдлыг бий болгосон. Тодруулбал, ордын нөөц их байх тохиолдолд төр уг ордыг үнэ төлбөргүйгээр өөртөө шилжүүлж авах эрх зүйн орчинг бүрдүүлсэн нь салбарт оруулах хөрөнгө оруулалтыг шууд царцаах, хязгаарлах шинжтэй зохицуулалт болсон ба уг зохицуулалт нь Үндсэн хуульд заасан өмчийн эрхийг шууд зөрчихөөр байна. Үүний улмаас ордын нөөцийг нэмэгдүүлэх төрийн бодлогод ч сөргөөр нөлөөлөх ба нэмж нөөц тогтоох хувийн хайгуулын ажлууд ч зогсохоор байна. Үүнээс хамаарч төрөөс Үндэсний баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэх бодлогод ч хуулийн дээрх өөрчлөлт сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймээс Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтыг Үндсэн хуульд нийцүүлэх, улмаар чухал ашигт малтмалын төслийг дэмжих замаар Үндэсний баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулж байна.

Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төслийн зорилго нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх, ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг дэмжин, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бий болгох юм.

Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хувийн өмчийн эрхийг зөрчихгүйгээр, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Төрийн нийтийн өмчийн үр өгөөжийг хуульд тодорхойлсноор, бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин тодорхой болж, бизнес эрхлэх таатай, тогтвортой орчин бүрдэнэ.

Түүнчлэн, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, үүнтэй холбоотойгоор хайгуулын ажил эрчимжин, Монгол Улсын газрын хэвлийн баялгийн нөөц нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар чухал ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс гадна, уул уурхайн төслөөс хүртэх нийгмийн үр өгөөжийг тодорхойлж, нөлөөлөлд өртөх иргэдийн эрх, ашгийг хангах нөхцөл бүрдэнэ.

Энэхүү хуулийн төслийн үр дүнд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ордын том, жижгээс үл хамааран ижил, тэгш нөхцөлөөр хүртэх эрх зүйн орчин бүрдэх ба Үндэсний баялгийн сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Ингэснээр өнөө болон ирээдүйн цагийн иргэдийн байгалийн баялгаас хүртэх өгөөжийг нэмэгдүүлж, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх нөхцөл бүрдэх юм.